



Б А Р У У Н Б Ü Р Э Н С У М Ы Н М О Н Г О Л  
А Р Д Ы Н Н А М Ы Н Х О Р О О Н Д

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2020-04-30 № 018-2020/04-НА-03  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баруунбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Баруунбүрэн сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Баруунбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Баруунбүрэн сумын Монгол Ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.


## Дүгнэлт

Баруунбүрэн сумын Монгол Ардын намын хорооны Баруунбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баруунбүрэн сумын Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр 1.3... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Баруунбүрэн сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАРУУНБҮРЭН СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020.06.20



**ЭХ НУТГИЙНХАА ТӨЛӨӨ  
“ХҮЧЭЭ НЭГТГЭЭ”**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЭРҮҮЛ МЭНД, БИЕЙН ТАМИР, СПОРТ, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛ**

- 1.1 Иргэдийн идэвхтэй эрүүл амьдрах дадал хэвшлийг бий болгох арга хэмжээг зохион байгуулж ажиллана.
- 1.2 Эрүүл мэндийн салбарын ажилчдын орон тоог хангаж ажиллах, эмч нарыг чадавхжуулах, давтан сургах мэргэшүүлэх чиглэлийн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулна.
- 1.3. Эмийн хөнгөлөлтийн үйлчилгээг тэгш хүртээж ажиллана.
- 1.4. Цэцэрлэгт хүрээлэн ногоон байгууламж барих зураг төсөв, тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 1.5. Амарбаясгалант хийдийн орчныг аялал жуулчлалын бүс болгох хилийн заагийг тогтоож, түүх соёл, нүүдлийн соёл иргэншил, иргэдийн оролцоонд тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 1.6. Хүүхдийн тоглоомын талбайн байгуулна.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. МАЛ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАН**

- 2.1 Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллана.
- 2.2 Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг тэжээлийн аж ахуй байгуулахад бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.3 Малын арьс шир, сүү, сүүн бүтээгдэхүүнийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх иргэдийг төсөл хөтөлбөрөөр дэмжиж ажиллана.




- 2.4 Газар тариалангийн талбайг хашаажуулах ажлыг бодлогоор дэмжинэ.
- 2.5 Хил залгаа сумуудтай хил орчмын бэлчээр нутаг ашиглах тал дээр гэрээний үндсэн дээр хамтран ажиллана.
- 2.6 Өвөл зуны хүлэмжийн аж ахуйг эрхлэх иргэдийг олон улсын байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөрт хамруулна.
- 2.7 Малын үйлчилгээний нэгдсэн цэгүүдийг бий болгоно.
- 2.8 Иргэдийн төмс хүнсний ногооны талбайд суваг шуудуу татах, гүний худаг гаргах ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.9 Малын худалдаа, түүхийн эдийн нэгдсэн цэг байгуулна.
- 2.10 Төмс хүнсний ногоог борлуулалтын сүлжээ бүхий газруудтай холбоно.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН - НОГООН ХӨГЖИЛ**


- 3.1 Гол ус булаг шандын эхээс мод бэлтгэх ажлыг зогсоож хашаажуулж, хамгаалалтад авна.
- 3.2 Ойг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлнэ.
- 3.3 Биологийн олон янз байдлыг тэнцвэржүүлэх арга хэмжээ авч хамгаална.
- 3.4 Ойн нөхөрлөл буюу мэргэжлийн байгууллагын мод бэлтгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, орон нутагт оруулах үр ашгийг нэмэгдүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч ажиллана.
- 3.5 Газрын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, үйлчилгээг сайжруулна.
- 3.6 Бэлчээрийг зөв зохистой ашиглах сэргээх зорилгоор сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөө гаргаж ажиллана.
- 3.7 Малчдын бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ДЭД БҮТЭЦ**

- 4.1 Баруунбүрэн сумын дэд бүтэц, цэвэр бохирын шугамыг засварлаж нэгдсэн цэвэрлэх байгууламжийн зураг төсөв, тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.



4.2 Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын авто зам дагасан зочид буудал, зоогийн газар, боловсон бие засах газар, автомашины зогсоол, авто засвар, түргэн үйлчилгээний цэг зэргийг байгуулах санал, санаачилгыг дэмжиж ажиллана.



4.3 Гэр хорооллын цэвэр усны шугамыг өрх бүрд хүргэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.

4.4 Сумын төвийн явган хүний замыг сайжруулан, засварлана.

### ТАВДУГААР БҮЛЭГ . ЭДИЙН ЗАСАГ

5.1 Өрхийн үйлдвэрлэлийг дэмжинэ.

5.2 Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хүрээнд хаягдал модоор бүтээгдэхүүн үйлдвэрлэх иргэдийг дэмжиж ажиллана.

5.3 Жижиг дунд болон гарааны бизнес эрхлэгчдийг төрийн худалдан авалтаар дотоодын давуу эрх олгон дэмжинэ.

5.4 ХАА, хөнгөн үйлдвэрийн түүхий эдээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бэлтгэн нийлүүлэх, боловсруулах загвар төслүүдийг орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Үүнд: ХАА-н гаралтай түүхий эдээр бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон мал бордох газар, мужааны цех, модны үрсэлгээ, суулгац тариалах аж ахуйн нэгж, иргэдийн үйлдвэрлэл, тариалалт эрхлэгчдийг хамруулна.

### ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ЗАСАГЛАЛ

6.1 Төрийн албаны бүх томилгоо сул орон тоог нөхөхдөө холбогдох хуулийг баримталж ажиллана.

6.2 Төрийн албан хаагчдын хүнд суртал үйлчилгээний ёс зүйг цахимаар хянаж дүгнэдэг системийг бий болгоно.

6.3 Төсөв санхүүгийн сахилга хариуцлагыг чангатгаж, төсвийн хөрөнгийг нийгэм, эдийн засгийн хөгжилд оновчтой, үр ашигтай зарцуулахад иргэд, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлнэ.



БАНУУНБҮРЭН СУМНЫ МОНГОЛ  
АРДЫН НАМЫН ХОРОО